

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 7.6 тэрбум төгрөг орж, урьд оны мөн үеэс 0.2 хувиар доогуур байна.

Төсвийн орлогын төлөвлөгөө нь Баруун-Урт 18.3 хувь, Дарьганга 5.7 хувиар тус тус тасарсан байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 5.9 тэрбум төгрөг болж, урьд оны мөн үеэс 0.4 тэрбум төгрөгөөр доогуур байна.

461.7 сая төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт хийгдсний дотор 258.6 сая төгрөг нь төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын салбарт, 123.1 сая төгрөг нь нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээнд, 40 сая төгрөг нь боловсролын болон эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт тус тус оржээ.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 45.5 тэрбум төгрөгт хүрсэн нь 2011 оны жилийн эцсээс 10.4 тэрбум төгрөгөөр, урьд оны мөн үеэс 12.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн хадгаламжийн хэмжээ 21.4 тэрбум төгрөг болсон нь 2011 оны жилийн эцсээс 4.6 тэрбум, урьд оны мөн үеэс 6.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 83.9 хувь болох 757.9 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.3 хувь болох 758.6 мянган төл бойжиж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 34.5 мянгаар дээгүүр байна.

Оны эхний малын 0.7 хувь болох 13.9 мянган том мал зүй бусаар хорогдсон нь урьд оны мөн үеэс 31.8 мянгаар буурсан байна.

Газар тариалан: Төмс 631.4 тн, хүнсний ногоо 199.4 тн-ыг хураагаад байгаа нь урьд оны мөн үеэс төмс 30.6 тн, хүнсний ногоо 10.9 тн-оор тус тус дээгүүр байна.

Байгалийн хадлан 10.5 мянган тн, тэжээлийн ургамал 99.8 тн, гар тэжээл 564 тн тус тус бэлтгэсэн нь урьд оны мөн үеэс хадлан 918 тн, тэжээлийн ургамал 84.7 тн, гар тэжээл 46.4 тн-оор тус тус дээгүүр гүйцэтгэлтэй байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 22.9 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 2.7 тэрбум төгрөгөөр дээгүүр байна.

Оны үнээр 92.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 13.5 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн 49 бүтээгдэхүүнээс 18 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн байна.

V. БАРИЛГА, ТЭЭВЭР, ХОЛБОО: Барилга: Орон нутгийн барилгын байгууллагууд 2885.3 тэрбум төгрөгийн, гадны барилгын байгууллагууд 11317.2 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь урьд оны мөн үеэс 10.4 тэрбумаар дээгүүр байна.

Тээвэр: Тээвэр бүхий байгууллагууд 33959.0 мян.тн.км-ийн ачаа эргэлт, 25074.8 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийж, 5.0 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Холбоо: Холбоо ашиглалтын орлого 335.3 сая төгрөг байгаагийн дотор 138.7 сая төгрөг нь хүн амаас орсон байна. Телефон цэгийн тоо 1500 болж урьд оны мөн үеэс 5.6 хувиар буурсан байна.

VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 9-р сард өмнөх сарынхаас 1.8 хувь, өнгөрсөн оны жилийн эцсээс 7.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 16.9 хувь, 2010 оны зэрэгцүүлэх үнээс 19.7 хувиар тус тус өслөө. Оны эхнээс 9-р сард 7.5 хувиар өссөний дотор холбооны бүлгээс бусад бүлгийн үнэ 2.6-44.6 хувиар өссөн нь нөлөөлжээ.

VII. СОЁЛ, БОЛОВСРОЛ: Соёл: ХЖТеатр 14.6 мянган үзэгчдэд 51 удаа тоглолт хийж, 11.9 сая төгрөгийн орлоготой ажилласан.

Музей: 1.8 мянган үзмэрээр 1.2 мянган хүнд үйлчилж, 1459.2 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Нийтийн номын сан: 21.2 мянган уншигчдад 43.3 мянган номоор үйлчилж 162.5 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ.

Боловсрол: 2012-2013 оны хичээлийн жилд нийт 15 ЕБС-д 510 үндсэн багш багшилж, 354 бүлэгт 9.9 мянган сурагчид суралцаж байна. Үүнээс 1-р ангид 882 сурагч элсч, 11-р ангид 676 сурагч суралцаж байна. Аймгийн хэмжээнд нэг багшид дундажаар 20 хүүхэд ноогдож байна. 1033 сурагч дотуур байранд сууж байна.

VIII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 5.4 тэрбум төгрөг болж төлөвлөгөө 12.6 хувиар өссөны дотор сайн дурын даатгуулагчид 0.1 тэрбум төгрөгний шимтгэл оруулж, төлөвлөгөө 17.1 хувиар давж биелсэн байна. 6138 өндөр настанд 9.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгожээ. Нийгмийн халамжийн сангаас 1.5 тэрбум, улсын төсвөөс 12.9 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

IX. ЭРҮҮЛ МЭНД: Төрөлт нэмэгдэж, 972 эх амаржиж, 983 хүүхэд төрсөн нь урьд оны мөн үеэс 21-ээр дээгүүр байна.

Халдварт өвчнөөр 485 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 64-оор олон байгаа бөгөөд гепатит, цусан суулга, салхинцэцэг, тэмбүү, трихоминиаз зэрэг өвчлөлүүд өссөн байна.

X. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 855 болж, урьд оны мөн үеэс 98-аар буурсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 72.9 хувь нь 16-34 насны залуучууд байна. Боловсролын хувьд 24 хувь нь дээд, 2.9 хувь нь тусгай дунд, 40.5 хувь нь бүрэн дунд, 6.9 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

1137 хүн шинээр бүртгүүлж, 950 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 517 хүн ажиллаж байна.

XI. АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН, ОРЛОГО: 2-р улирлын түүвэр судалгаанд хамрагдсан 40 ААНБ-ын ажиллагчдын дундаж цалин, орлогыг авч үзэхэд: Санхүү, уул уурхай, цахилгаан эрчим хүч, тээвэр, холбоо, үл хөдлөх хөрөнгө, боловсрол, төрийн удирдлага, батлан хамгаалахын салбар өндөр үзүүлэлттэй байна.

XII. ГЭМТ ХЭРЭГ: Эхний 9 сард гэмт хэргийн үзүүлэлт өсч, 176 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 4.1 хувиар өслөө. Гэмт хэргийн улмаас 32 хүн нас барж, 52 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 179.6 сая төгрөгийн хохирол учирсны 166.6 саяыг нь нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 142 хүн холбогдон сэжиглэгдсэний 23.2 хувь нь согтуугаар, 8.4 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн нь урьд оны мөн үеэс 40.0-89.2 хувиар буурсан байна.

Нийт 2527 хүн эрүүлжигдэж, 107 хүн баривчлагдсан нь урьд оны мөн үеийнхээс өссөн байна.


XIII. ДААТГАЛ: Даатгалын байгууллагуудын хураамжийн орлогоор 258.9 сая төгрөг орсон нь урьд оны мөн үеэс 2.6 дахин давж биелсэн. 353 хүнд 18.1 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ.

XIV. ТӨСӨЛ: ХЭДСАН: Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 260 иргэнд 637.4 сая төгрөгийн зээл олгож, 644 ажлын байрыг бий болгосон байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж 13 суманд 1.3 тэрбум төгрөгийн зээл олгож, ажлын шинэ байр 248-аар нэмэгдсэн байна.

ТА-2 төсөл: Тогтвортой амжиргаа II төслийн хүрээнд аймгийн хэмжээгээр 142.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

XV. ГАЗАР ӨМЧЛӨЛ: Аймгийн хэмжээгээр нийтдээ 6271 иргэн өргөдөл гаргаж, 6082 иргэний өргөдлийг шийдвэрлэж, 572.81 га газрыг өмчлүүлээд байна.



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС